

НОГООН ЭДИЙН ЗАСАГ БА НҮҮДЭЛЧДИЙН АХУЙ СОЁЛ

Н.ОТГОНБАЯР

Отгонтэнгэр Их Сургуулийн Эдийн засаг бизнесийн
удирдлагын сургуулийн багш, доктор (Ph.D) Электрон
хаяг: otgonbayar@otgontenger.edu.mn

Хураангуй

Нүүдлийн соёл иргэншилтэй Монголчууд эдийн засгийн түүхэнд ан агнаж, мал аж ахуй, голлож, жимс жимсгэнэ, газар тариалан, зэрэг байгалийн нөөц баялгийг хэрэглэж, худалдааны салбар туслах аж ахуйн хэлбэртэй хөгжиж ирсэн түүхтэй билээ. Энэ нь байгалийг ашиглах үйл явц, яаж эзэмшиж, захирах нь байгальтай харьцаж, тэнцвэртэй байдлыг Монголчууд төгөлдөржүүлж, байгаль экологид ээлтэй ногоон эдийн засгийн ач холбогдлыг, нүүдэлчдийн ахуй соёлын түүхээс харах бүрэн боломжтой үйл явц юм. Ертөнцийн цөм төв нь байгалийн хамгийн боловсронгуй бүтээл, түүний хэсэг нь болох хүн юм.

Түлхүүр үг: Нүүдэлчдийн соёл иргэншил, өвөг дээдэс, ногоон эдийн засаг, мал аж ахуй, газар тариалан, засаг агнуур, тогтвортой хөгжил, хэрэглээ, гемостац

Танилцуулга

Ногоон эдийн засаг гэдэг нь “Хүний сайн сайхан, нийгмийн тэгш, хүртээмжтэй байдлыг сайжруулахын зэрэгцээ байгаль орчны эрсдэл, экологийн доройтлыг эрс бууруулж чадаж буй” эдийн засгийг хэлнэ. Ногоон эдийн засгийн хамгийн энгийн тодорхойлолт нь хүлэмжийн хийн ялгарал багатай, нөөцийг үр ашигтай зарцуулдаг, нийгмийн тэгш, хүртээмжтэй байдлыг хангах юм гэж тодорхойлсон байдаг. Ногоон эдийн засаг нь дэлхий ертөнцийн бүхэл бүтэн системийг, өөрөөр хэлбэл, байгаль экологи болон байгалийн олон янз байдлыг цогцоор нь хамтад нь авч үздэгээрээ онцлогтой гэжээ. НҮБ-ын төрөлжсөн таван байгууллагын санаачилгаар “Ногоон эдийн засгийн төлөөх түншлэл” хөтөлбөрийг 2013 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд анхны гишүүн орны нэг нь манай улс юм. Тус хөтөлбөр нь ногоон хөгжлийн замналаар хөгжиж байгаа улс орнуудад бодлогын дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг¹. Байгаль экологид ээлтэй ногоон эдийн засгийн ач холбогдлыг Нүүдэлчдийн ахуй соёлоос харах бүрэн боломжтой. Нүүдэлчин Монголчууд эрт дээр үеэс ард түмнийхээ хэрэглээг байгаль экологийн эрсдэлийг тооцоолж ухаалаг арга замаар хангаж байсныг нүүдэлчдийн түүх гэрчилнэ. Тухайлбал нүүдэлчдийн хүнсний хэрэглээнд ан агнуур зонхилж байсан бөгөөд XI-XII зууны үеийн Монголчуудын ан агнуурын тухай мэдээ “Монголын нууц товчоон”, “Судрын чуулган” зэрэг сурвалжуудад тодорхой тусжээ.

Ногоон аж ахуй ба ан агнуур

Монголд ан агнуурын уламжлал нэн эртний түүхтэй, ууган аж ахуй бөгөөд гөрөөлөхүй, загасчлахуй, шувуучлахуй гэсэн 3 төрөл хөгжиж иржээ. Ан

¹ Ногоон эдийн засгийн бодлогын дүн шинжилгээ, Монгол улс, 2018

хийх далайцаар нь: ан агнуур, ав хоморго, хаана авлаж байгаагаар нь: ой хөвчийн, уул хадны, тал хээрийн, говь цөлийн гэж хувааж болно.

Гөрөөлөхүй: Монгол нутгийн хадны сүг зургийн хамгийн өргөн сэдэв бол ан амьтан,

агнуур юм.

XI-XII зууны үеийн Монголчуудын агнах гол амьтад нь буга, аргаль, угалз, булга, хэрэм, тарвага, зээр, шилүүс, үнэг зэрэг бөгөөд гол үүрэгтэй нь буга, булга 2 юм. Тулгар бичгийн баримтаас үзвэл дээр дурдсан амьтдыг агнахыг ерөнхийд нь *авлахуй* гэдэг. Тус тусад нь авлахыг тарвагачлах, гөрөөчлөх, шувуучлах гэх мэтээр тусгайлан нэрлэнэ. Ерөөс сүрэглэдэггүй амьтдыг ганц нэгээр олж агнахыг **хайдаг ав**, сүрэглэн идээших амьтдыг нийтийн хүчээр олноор авлахыг **зээгт ав** гэдэг шиг байна. Ийм авд 30, 40, түүнээс илүү хүн ч оролцдог, нутаг хошуу, нийт нийгмийн ач холбогдолтой зүйл байсан.

Жнь: Цэргийн дасгал сургуулилт, байлдааны цагийн нөхцөл байдал, арга ажиллагаанд эр, агтыг сургах, дасгах, цэргийн хүнсний нөөц бүрдүүлэх, хаад, ихэс дээдсийн зугаа цэнгээн, малын дайсан чоныг дарах, дайжуулах мэт.

Нанхиад сурвалжид “Намрын хонгор салхи дэгдэж, өвс ногоо шарлаж эхлэхэд зэвсэг чанд, адуу тарган, ан гөрөө махалсан тул цуглаж авламуй. Монголчуудын аймгийн тэргүүлэгчдээс зарлиг буулгаж, ой тайгад эгц улаан болж, мянга түмэн морьтон пижигнэлдэн давхилдаж ав эхэлмүй. Хэдэн сараар буцахгүй авлаж, ан гөрөөсийг уул мэт овоолон олноороо хуваалдана. Энэ бол хэн бээр өөрчилж болохгүй хууль тогтоол болой” гэж тэмдэглэжээ.

Мөн Хятадын жуулчин Сяо Да Хэн “Монголчуудын зан заншил” хэмээх тэмдэглэлдээ “Ан агнах нь Монголчуудын байнгын үйл болсон боловч ангийн төрж бойжих, хайрлах ёсыг бас мэднэ. Иймийн тулд хавар, зун цагт авлахгүй” гэжээ. Түүхч Буянчуулган “Аж ахуйн тэмдэглэл” хэмээх номдоо “Цагаан зээрийг нар буцаж ес эхлэх хүртэл агнана. Хяруу унаснаас хаврын урь хүртэл үнэг, хярс, чоно агнана” гэсний дээр монгол анчдын хурай дуудлагад

“Өөхөө даахгүй тарганаас нь Өвсөө
даахгүй хөгшнөөс нь Идэхэд сайхнаас нь

Эдгэхэд сайнаас нь өгөн соёрх” гэж өгүүлдэг нь монгол агнуурын гол зарчим байна. Ангийн хээл томорсон, төл орсон үеэс агнуурыг зогсоож, үр төлөө дагуулсан эмэгчин амьтанг агнахгүй, харин тарвага, зурам, загас зэргийг агнадаг байжээ. Агнуурын арга, зэвсэг нь нутаг нутагт, ямар ан агнах гэж байгаагаас шалтгаалан янз янз.

- **Занга тавих:** 2 арга байдаг. Ой хөвчид тураг ан агнахад нүх ухаж өвсөөр битүүлээд анг унагаж агнах арга, **бүдрэг** гэнэ. Хөвч хангайд энэ аргыг **унанга** гэдэг Хандгай, буга, гахай зэрэг тураг (том) гөрөөсийг ихэвчлэн ийм аргаар агнадаг. Жижиг махчин амьтанг нүх гарцан дээр том даацын чулуу мэт зүйлийг оньсолж толгой биеийн хэсэг нь хүрмэгц дарах аргаар агнах хоёр зүйл.

- **Хаж тавих:** Говь талын анчид зээрэнд ихээхэн хэрэглэнэ. Мод чулуу муна зэргийг олс дээсэнд чиргэж, тавиад сүргийг шахаж оруулахад нэг нь ороолдож, муна хянгарт хөлөө цохиулан, цовхчих тоолонд улам чангарч, улам их цохиулж, хөл хугарч, шөрмөсөө таслуулан зогсоно.

- **Шигшрэг дуудлага:** Улих, урамдах мэтээр амьтны дуу авиаг дуурайх, жижиг амьтад тарвага зурам ноцолдох мэт дуу гарган, араатан амьтдыг дуудаж

ойртуулан агнах арга. Шууширах, Шигширэх, Бөлбөөлөх, уриадах гэх мэтээр нэрлэнэ.

- **Тэмээ түлхэх арга:** Говийн анчид зээр, гөрөөс, чоно зэргийг агнахдаа тэмээний бурантгийг нарийн савааны үзүүрт уян түлхэж ойртдог.

- **Утах арга:** Нүхэнд нь галын утаагаар утах арга, хориотой арга юм. нүх ухах, ус цутгах ч бий.

- **Богжоох:** өвөрмөц арга. Намрын сүүл сард анхны цас орох үед ангийн халуун мөрөөр орж, 2, 3 өдөр дагаж, цуцааж ядраах арга юм. Сэлэнгийн Ерөө голын Хамниганчууд өргөн хэрэглэдэг.

- Тарвага, үнэг, гөрөөс зэрэг анг бүргэд харцага зэрэг **шувуу, нохойгоор бариулах**

- Уулын анчид уул цармын дунд байгаа анг шууд **тэшүүрээр буун**, жадалж, бүлж

агнадаг байсан содон мэдээ бий. Дээрхи аргуудаас гадна сааль, хаж, дүүгүүр, хавчирга-хавх, урхи, занга зэрэг олон төрлийн зэвсэг бий.

- **Хавчрага** гэдэг нь ангийн хөл хавчиж агнах бөгөөд хавх юм. Монгол дархчууд өөрсдөө хийхийн зэрэгцээ Оросоос худалдаж аван чоно, үнэг, тарвага зэрэг амьтдын нүх, хаяг гүйцэд тавьж агнана.

- **Сааль зэвсэг:** Нийт Монголчуудын дунд өргөн дэлгэрсэн боловч ялангуяа, Урианхайчууд, Тува, Цаатан ардуудад илүү түгээмэл байдаг, цор ганц өөрөө хөнөөгч зэвсэг юм. Чоно, Баавгай, Хандгай, зэргийг агнадаг. ХХ зууны эхээр саалиар ан хийхийг хориглож эхэлсэн бөгөөд 1931 онд зөвхөн Тожийн тувачуудад 1210 сааль бүртгэгдсэн байдаг. Саалийг хийхдээ суурийг шинэс модоор хийж, урд хэсэгт нь нум бэхлэн, дээд хэсэгт нь нумны ховил гарган нуманд үдээрээр хийсэн хөвчийг хялгасан гогцооны тусламжтайгаар модон гохонд тогтооно. Гогцоонд урт хялгасан дээсэн хэц бэхэлж амьтны замыг хаах бөгөөд хэцэнд ан хүрсэн тохиолдолд гох мултарч харвадаг. Өндрийн хэмжээг тохируулахдаа харвуулсан тухайн амьтанд үхлийн шарх өгөхөөр тооцоолж байрлуулна. Саалийг тавихдаа 2-3 хоногийн өмнө тухайн газраа байрлуулж ангийн гүйдэл бүхий онь хөтөлийг сонгоно. Гүйдлийг тосгож хэд хэдэн сааль тавьдаг. Хэцний үзүүрийг эсрэг талд нь хийж саалиа суурилуулж, нум татан уяаг нь тохируулж бэлтгэнэ. Сааль тавьсанаа бүгдэд зарладаг. Урианхайчуудын дунд “саальч хүн салиндаа, усч хүн усандаа” гэдэг үг ч бий. Энэ нь сааль аюултай зэвсэг, нөгөө талаар тусгай мэргэжлийн хүн тавьдаг болохыг илтгэж байна. “Монгол Ойрадын Их цааз”-д сааль зэвсэгтэй холбоотой 5 заалт бий. Жишээ нь: Зартай саальд хүн үхвэл 1 бэрхээр босго (9 толгой мал өг). Заргүй саальд хүн үхвэл 5 ес ав. Эдгэвэл 5 ав гэх мэт. Тува, Урианхайчууд дунд сааль зэвсгийн тухай оньсоголон хэлэлцэх нь бий. Жишээ нь:

Шугуй дотор сохор чөтгөр Хаданд
хадсан чөтгөр Хамаг юмыг гэтсэн чөтгөр
Хээр гэтсэн чөтгөр
Хэрэг тарьсан чөтгөр Харгуйд хатсан
чөтгөр
Харанхуй шөнө отсон чөтгөр гэх мэт.

- **Суулга занга:** Баяд, Дөрвөд, Алтайн Урианхайчууд өргөн хэрэглэнэ. Суусар, хадны булга зэрэг жижиг үслэг ан агнахад хэрэглэнэ. Модоор жижиг ухмал бортого хийж таглааг дотогш эргэж хаагддаг байдлаар хийнэ. Бортогын

оосрыг хялгас ноосоор хийнэ. Тарвага зурам, адууны мах зэрэг хурц үнэртэй махыг суулганы аман дээр тавина. Заавал хаданд өлгөнө. Энэ нь занганд орсон амьтан савтайгаа өнхөрч таг нээгдэхээс болгоомжилсон хэрэг. Ан амьтны үс сор гүйцсэн өвлийн дунд сараас хаврын дунд сар хүртэл тавьдаг.

- **Басвага:** Захчид **басмаг** гэж нэрлэдэг. Алтайн Урианхайчуудаас Манжийн эзэн хаанд үслэгийн ан барих болсноор тус зэвсгийг хэрэглэх болжээ. Шор ивүүр тулгуур зэргээс бүрдэнэ. Шорыг хатуу хар модоор 20-25 см урттай хийнэ. Ивүүр нь 2-3 см диаметр бүхий 5-7 см урттай бөөрөнхий мод болно. Тулгуур нь 30-35 см урт. 1-2 см диаметртэй. Тураг анд тавихгүй. Булга, суусар зэрэг жижиг үнэт үслэг анд тавина. Тавихдаа анчин тарвага, адууны зэрэг үнэрлэг, хальс шөрмөстэй махыг газраар чирж очих бөгөөд үүнийг *мин* гэнэ. Минг шоронд шорлож жижиг чулууг суурь болгон суурь дээр ивүүр тавьж ивүүр дээр шортой мах, шорон дээр тулгуураа тулж мөн томоохон чулууг түшүүр болгон тогтооно. Амьтан махны үнэрээр ирж шортой махыг идэх гэж оролдоход ивүүр өнхөрч түшүүр чулуу дарж агнадаг.

- **Дүүжин урхи:** Нүхний амьтад болон жижиг ан агнахад хэрэглэнэ. Нуур голын хөвөө усны жим газар, мод бургастай газар тавьдаг. Торгууд нар өвлийн цагт шувуу хоноглох газар нарийн хэц татаж хэцнээс хялгасан урхи зүүж тариа будаа цацаж орхидог. Урхинд орсон аливаа амьтан хөдлөх бүрт чангарах байдлаар хийдэг. Урхи нь шууд урхи, мунат урхи, чиргүүлт урхи зэрэг олон янз байна. Дүүжин урхийг Баяд, Дөрвөд, Торгууд ястнууд өргөн хэрэглэдэг. Хярс, туулай, ятуу зэргийг агнана. 3 модыг үзүүрээр нь зөрүүлж боогоод, түүний салаан дээгүүр унанги модыг дамнуулан тавьж,

нарийн үзүүрт нь урхи уяж унжуулаад мах өөхний зүйлийг газарт хаяж бүдүүн үзүүрээс нь ойролцоо ургаа модны яр уранд мөчидхөн тээглүүлнэ.

Загасчлахуй: Загасчлал неолитын үеэс аж ахуйд нэвтэрсэн байна. Мөн үеийн дурсгалд загас барих сүлжмэл тор холбогдоно. Монголчуудын загас агнуурын зэвсэг нь ган дэгээ, утас томж хийсэн сүлжмэл тор байсан.

Дорнодын Олон нуур, Буйр, Тэрхийн цагаан нуур, Орхон, Сэлэнгэ, Хэрлэн голынхон ихэвчлэн загасчлан аж төрдөг. Сэлэнгийн цутгалан: Чулуут, Суман голын уулзварт нутаглагсдыг *тулынхан* гэх нь ч бий. Хэрлэн голын хавиар усны хаялгаар гарсан загасыг нутгийн иргэд түүж идэх ёс ч байжээ. Монголын нууц товчоонд; **хадран, зэвгэ, сугас, хэлэм, тул** гэх мэт олон зүйлийн загасны нэр гарч байна. Эдгээр нь агнуурын гол загас байжээ.

Үхрийн хялгас, адууны дэл, сүүлээр сүлжсэн тороор тул, цурхай мэт том загас, эргэгч тороор дунд зэргийн загасыг, хульма тороор бүр жижиг загасыг барьдаг.

Шувуучлахуй: Шувуучлахуйн тухай анхны мэдээ түүх сударт “Мон хан” гэж тэмдэглэгдсэн, Бутанцар мунхаг Онон мөрний хөвөөнд харцага тэжээн шувуучилж байсан тухай баримт юм. МНТ-д; Чингис хаан биднийг шувуу агнахад хэвтүүл бидэнтэй хамт шувуу агнан явтугай. Хэвтүүл шувуу агнан явахад бусад нь ар гэрээ сахин явтугай мэтээр буй. Шувуучлахуй гэдэг нь;

- 1) Харцага, шонхор, бүргэд мэт хүчит, махчин шувууг тэжээн ан бариулах
- 2) Шувууг өөрийг нь агнах хоёр янз байна.

Агнуурын зарим зан үйл: Ангийн үйлс бүтэмжтэй байхыг бэлгэдсэн зан үйл их түгээмэл байдаг. Жишээ нь;

- Анд явах товлосон өдрийг хэлдэггүй. Өдөр товлехдоо далд утгаар юм өгч авалцаж ойлголцдог.

- Хэл ам, хэрүүл маргааныг цээрлэнэ. Хоосон байхгүй, алга байна гэж бэлгэшээлгүй үг хэлэхгүй.

- Анд голчлон үүрээр морддог. Гал голомт, гэрийн сахиусаа тахиж, буугаа сангаар ариулдаг. Гэрийн хойд талаас нар зөв гурвантаа тойрч гардаг. Анд явах замд; чоно, туулай таарвал бэлгэшээнэ, үнэг таарвал цээрлэж, ялангуяа өврөөс гарч /зүүнээс баруунш/, өмнүүр явбал буцах нь ч бий.

- Анг нэрээр нь дууддаггүй. Жишээ нь, *чоныг: хангай, алтан соёот, унжуу сүүлт, боохой, өвгөлдэй, өнөөх, жийхгар, эрүү нь хувхайрмар, булган сүүлт, хээрийн нохой, саарал, хээрийн амьтан* гэх мэт, гахайг *түгдгэр*, бугыг *тураг*, тарвагыг *хулгар шар*, баавгайг *өтөг*, ирвэсийг *барзгар, цоохор* гэхчлэн нэрлэж заншсан байна.

- Уул усанд идээний дээж өргөн цацал цацаж ганзгаа ангийн цусаар мялаадаг.

- Баруун Монголчууд анд гарахын өмнө Тууль хайлуулна. Анчид тусгай үлгэрч туульчдыг дагуулдаг.

- Аливаа анг **Алтайн хишиг, Хангайн хишиг** гэж хэлдэг.

- Томоохон ан агнахдаа санамсаргүй юм уу, аргагүйдэж агнасан тухай ярьдаг. Жишээ нь;

“Алъя гэж алсангүй Алтай хангай надад өгсөн” юм гэх, “Алтай Хангай минь хайнагийн шар юм уу нэг юм өглөө. Алъя гэж алсангүй сум тэнэж онолоо. Хайрхан минь” гэх.

- Ганзага сэтэлж авахгүй заавал майлж авдаг. Унтуу тавих гэж сонин зан үйл бий. Тусгалаа алдсан, онохоо больсон зэвсгийг гэрийн босго, хавчист дэрлүүлэн тавьж, эмэгтэй хүн алхуулах, ан барихаа больсон нохойг гэрийн эзэгтэй 3 галын дундуур гарган, ханцуй нударгаар зодож, *унтуу тавь унтуу тавь* хэмээн зандардаг. Эмэгтэй хүн хүрч болдоггүй зүйл бол буу, нохой зодох хориотой. Ардын ёсонд зорилтот үйл гэж байна аа.

- Ангийн гүзээ үлээж хатаадаггүй.

- Ангийн мах чанахад ус нэмдэггүй.

- Ангийн хишиг түгээхдээ түүхий мах өгөхгүй болгож өгдөг. Агнасан хүн *зүлдийг* нь өөрөө авдаг. Зүлд гэдэг нь эрүү, толгой, улаан хоолой, багалзуур, уушиг, зүрх. Зүлд

бол амьтны амин сүнс орших байр мөн бөгөөд энэ үгээс сүлд хэмээх үг гарсныг өмнө үгүүлсэн билээ.

Ангийн түүхий эдийг аль болох бүрэн оновчтой ашиглахыг зорино. Махан тэжээлтний арьс үсийг гоёл чимэглэл, дулаалгад, мах, эд эрхтэнг эмчилгээнд, шувуу, загас, өвсөн тэжээлтнийг голлон хүнсэнд, аль алийг эмчилгээ сувилгаанд хавсран хэрэглэнэ. Жишээ нь; Болжморын цусыг хүүхдийн чих өвдөхөд, бугын цусан эврийг ихэс саатах, нялхас халуурах өвчинд, бөхөнгийн эвэр ба махыг мөн халуунд, тарваганы арьсыг үе мөчинд, хойлгийн мах, чонын хэл, ходоодыг аливаа шарханд, уушгийг амьсгалын өвчинд болон сүрьеэнд, баавгайн махыг дотор өвчинд, гөрөөсний халуун цусыг багтраа мэнгэрт, доргоны өөхийг бадганатсан хүнд тус тус өгөх мэт.

Монгол эр хүн бүр зэвсэг барьдаг анчин, зөвхөн ангаар хүнс хоолоо залгуулдаг айл ч цөөнгүй байсан боловч ан амьтнаа хайрлах сэтгэл, өсөх төлжих цаг улирлыг бодолцон зохистой агнаж ирсэн өвөг дээдэс минь эртнээс энэ нутагт идээшсэн ан амьтанг толгойн тоо бүрэн бидэнд тушаасан боловч өнөө цагийн хурдан унаа, оночтой, алсын тусгалтай буу зэвсгээр ашиг хонжоог бодон

хоморголон устгасаар хамаг сайхан ан араатан жигүүртнээ зургийг нь “Улаан ном”-оос харж, тухайг нь уншиж мэдэх муу заяанд бидний үеийнхэн хүргэв бололтой.

Ногоон аж ахуй ба газар тариалан

Монгол уламжлалт аж ахуй эрхлэлтэд тариалан багагүй үүрэгтэй. Мезолитын сүүл, неолитын үеэс монгол газар тариалан эрхэлсэн тодорхой ул мөр ажиглагддаг, үр тариа хадгалах нүхт ваар, тариа цайруулах чулуун самбар, гар тээрэм зэрэг түгээмэл олддог.

2000 гаруй жилийн тэртээгээс Монгол нутагт усалгаат, анжист газар тариалан хөгжсөнийг гэрчилж, Баянхонгор аймгийн Баянбулаг сумын Бичигтийн амны хадны зурагт үхэр хөллөсөн анжисны дүрслэл үлджээ. Монголын эртний улсууд хийгээд аймаг ханлигуудын үеийн усалгаат тариалангийн ул мөр: өргөн болон шувтан төмөр анжис, хадуур, зээтүү, хүрз зэрэг багаж, нүхт ваар, уур нүдүүр, усны татаал шуудуу, далангийн мөр, зарим бичгийн мэдээ уламжилсан бий.

Чингис хаан 1212 онд Завхан голын савд цэргийн тариа эрхлүүлэх зарлиг гаргасан байдаг. Их Монгол Улсын нийслэл Хархорумд тариачин өрх 4648, тарих талбай 6400 хуваарь газар байж, албан тариалан эрхэлж, цэргийн хүнсэнд хар будаа, арвай, улаан буудай, амуу зэргийг нийлүүлж байсан сувалжийн мэдээ байна.

1800-аад он гэхэд 4 аймгийн 18 хошуунд тариалж байснаа хожим нэлээд өсч, XIX зууны эхэн гэхэд 6 аймаг, 1 хязгаар 7 нэгжийн /халх 4 аймаг, дөрвөд 2 аймаг, Ховдын хязгаарын/ 36 хошууны нутагт 182 усан дээр нийт 302 газар, 300000 га талбайд тариалан эрхэлж байжээ. Тариалангийн гол бүс нутаг Түшээт хан аймгийн Элдэн гүн, Баатар ван, Дайчин ван, Сайн ноён хан аймгийн Итгэмжит Бэйс, Хатан баатар вангийн хошуу, Ховд, Улиастайн ойролцоо /Буянт, Ховд голын сав/, Засагт хан аймгийн Дайчин ван, Номун хан хутагтын шавийн газар.

XIX зууны сүүл XX зууны эхэн гэхэд Монгол-Алтайн нурууны умар болон өвөр этгээд, Хангайн нурууны баруун өмнөд талын голууд, Орхон, Сэлэнгэ, Туул голын сав, Халх гол, Буйр нуурын орчим нутаглах халхчууд, Хархираа, Түргэн, Буянт, Ховд голын савын Ойрад монголчууд тариалан эрхэлж байжээ. Хангайн нурууны өвөр биеийн Таацын гол, Түй, Байдраг, Завхан голын нутаг, Алтайн өвөр бүсийн Биж гол, Аж богд, Бурхан буудайн уулын өмнө биеийн жижиг голууд дагасан тариалангийн тухай мэдээ чамлахааргүй байдаг.

Монгол тариалан Манж засгийн үед цэргийн гурил будааны хэрэглээ хангах зорилго бүхий Ховдын тарианы алба буюу *албан тариалан*, *ардын тариалан* гэсэн 2 хэлбэрээр хөгжиж XX зуунтай золгожээ. 1762 онд Ховдын тарианы алба эхэлж, Засагт хан, Түшээт ханы зарим хошууд, Дөрвөд 2 аймгийн ардуудаас Буянт голын хөвөөнд суулгаж, албан тариалан эрхлүүлэхийн зэрэгцээ тариа амуу будааг Хөххотын чиглэл дэх цэргийн баазуудад хүргэх тариан жингийн ажил эрхлэх 2 талтай.

Олноо Өргөгдсөн Монгол Улс байгуулагдсан цагаас тариалангийн ажилд анхаарч, 1914 оны гурван сард Засгийн газраас тариалангийн аж ахуй хөгжүүлэх шийдвэр гаргаж, аймгийн чуулган дарга нарт бичгээр мэдээлж байжээ. Энэ хүртэл хөгжсөн ардын тариалан дараахи онцлог, үндэсний хэв төлвийг бүрдүүлсэн байна.

Томоохон голын ай савууд хийгээд нуур голын хөвөөг дагаж үржил шим бүхий талбайг сонгож хөрсийг бордож сайжруулан тариалан эрхэлнэ. Талбайг сонгохдоо голын 2 хажуугийн чулуу бут дэрс багатай газар сонгож хамтын хөдөлмөрөөр зориуд цэвэрлэж засдаг.

Хөрс боловсруулах бордох арга нэн энгийн тухайлбал: Хонь, ямаа хотолж хэвтүүлэх, бод мал хурааж зогсоох, аргалын үнс усаар урсгах, жил өнжин тариалах, сэлгэж тариалах зэргээр хөрсний үржил шимийг сайжруулах хийгээд хадгална.

Сонгосон томоохон талбайг айлууд хувааж эзэмших бөгөөд газар хагалахын өмнө эхний усалгаа хийнэ. Энэ нь хөрсөнд чийг тогтоох, үр соёлоход ач холбогдол бүхий бөгөөд *газар ус* гэж нэрлэдэг. Хөрсөнд ус шингэж тэмээ мал явахад хальтрахгүй, хүрдэж цацахад шороо бутарч байх тохиолдолд газраа хагалж эхэлнэ. Талбайн нэг захаас нөгөө зах хүртэл жаал, жаахан зай буюу хамар үлдээж 20 орчим ам гүн анжис чирч хагална. Энэхүү тууш хагалгааг *газар тавлах* гэж нэрлэдэг. Ингэж хагалсны дараа анжисны мөр дагуулан үр цацаж дээгүүр нь илүүр буюу борной чирч, бүхэл шороог бутална. Засаж хамар шуудуу гаргана. Эдгээр хамар шуудуунуудыг хийх ам хоорондоо ойр, ус чөлөөтэй нэвчиж байхаар тохируулна.

Тариа услах шуудууг ардууд хүчээ нийлүүлж том голоос салбарлан татдаг байжээ. Энэ сувгийг *бух* гэнэ. Бухаас салбарласан хэсэг хүний талбай услах шуудууг *суман бух*, суман бухаас салбарлан гарсан тагтуудыг *тариа буюу чих* гэнэ. Бух нь 4м өргөнтэй, 1м гүнтэй байна. Галдан бошигт хаан Улаангомын газар усалгаат тариалан эрхлүүлж байсан ул мөр *Бошигтын бух* хэмээх усан татаалын мөр арилаагүй байна. Аль ч нутагт хаврын адаг сарын сүүлээс зуны эхэн сарын арван хэднийг хүртэл үрээ суулгадаг. Усалгаат тариаланг усалгааных нь үүднээс 2 үндсэн хэлбэрт хуваана.

1. Ус чийг ихтэй Орхон Сэлэнгийн сав газарт бараг усалдаггүй.
2. Монгол Алтайн хавийн нутгуудад усалгааны тоо нилээд арвин.

Тариалангийн арга ажилбар нь 3-4 жил энгийн аргаар бордоно. Тарих талбайг сонгосны хойно анхны боловсруулалт хийнэ. Тухайлбал хэсэг хэсэг дөрвөлжинд хуваана. Дөрвөлжинг *таг буюу тагт* гэнэ. Энэ нь 20-30 ам метр гэхдээ усны байдал байрлалаас хамаарч том бага янз бүр байна. Тагтыг зааглах шороон хашлагыг халхад *хамар*, захчинд *хөтрөн*, баядууд *чих* гэнэ. Таг хамар гаргасны дараа таригаар ус татаж тагт оруулна. 1 тагийн ус тэгш газар 20-30см байх бөгөөд дүүрмэгц хамрыг сэтлэн нөгөө тагт оруулна. Хөрсний байдлаас хамаарч тагт ус тогтоох хугацаа өөр өөр байна. Хагалж үр цацахын тулд услаж байгаа усыг *газар ус буюу хар шороон ус* гэнэ. Газар ус өгсний дараа 1-2 хоноод хөрс цайвартаж морь, тэмээ хальтархааргүй болсон хойно газрыг хагална. Хагалахын өмнө үр цацна. Алга дарам шимтэй атар хөрсөнд 5 ширхэг, элсэрхэг хөрсөнд 10 ширхэг үр цацна. Монгол үр ган гачиг хяруу хүйтэнд тэсвэртэй түргэн боловсордог. Тариаг асар нямбай хадгална. *Үрээ идэхээр үнээгээ ид* гэж хэлэлцдэг. Үр хэмжих нэгж *тоорцог малгай*. Газраа усалсны хойно морь, шар, тэмээнд анжисаа хөллөж газраа хагална. Зүтгэгч малыг нэг нь тууж, нөгөө нь хөтөлж, гурав дахь нь анжис дарна.

Хагалсны дараа модон булаар талбайг индүүднэ. Булаа морь тэмээгээр чирнэ. Ховд, Буянт голын саваарх талбайг 5 удаа усалдаг. Тиймээс *тариа таван устай* гэдэг үг гарсан. Өндөр уулархаг газар 5-7, говьд 2-3 удаа услана. Усалгаа

бүр нарийн хугацаатай голдуу 7, 21 хоногийн давтамжтай сөөлжүүлж хийдэг газар усаар тариа соёоны *шар чих буюу навч* гарч ирнэ. Үүнийг ургалт түргэсгэх үүднээс бог малаар зориуд идүүлнэ. Тариа соёолж үр ургаж 20 гаруй, зарим үед 40, 50 хоносон үед *хар шороо дарах ус* хийнэ. 7 хоногийн дараа тарианы үе булчин суулгах зорилгоор өмнөх уснаас арай их ус өгнө. Ингэхэд тарианы навч шимжиж, хар ногоон өнгөтэй болно. Тариа нь толгойлж, усан идээ сууж ирэх буюу түрүүчийн уснаас хоёр долоо, 21

хоногоос хэтрэхгүй ахин усална. Энэ усыг эзээ ус гэнэ. Үүний дараа 1, 2 тариан түрүү гарч ирнэ. Үрийн өсөлт бойжилт, хур чийгний байдлаас хамаарч, сүүлчийн удаа усалдаг. Үүнийг *хадуур ус* гэнэ. Үүний дараа тарианы үр уураг идээ боловсорч эхлэх бөгөөд үүнийг *аарц идээ авах* үе гэнэ. Идээшилт боловсролт удааширч тарианд хуурай салхи орвол давхар *хадуур усалгаа* хийнэ. Энэ нь *шунх* хэмээх өвчнөөс сэргийлнэ. Орхон, Сэлэнгийн савд үүнийг хаатах, захчингууд бэхтэх гэнэ.

Гантай жил ус хүрэлцэхгүй булаацалдах үе байдаг. Иймээс усгүй бол ургацгүй гэдэг үгтэй. Устай холбоотой хэрүүлийг *хэвийн* буюу *таригийн хэрүүл* гэнэ. Таригийн хэрүүлийг зохицуулах тусгай даамал ажиллах бөгөөд түүнийг *замьяа* гэнэ. Таригийн хэрүүлийг хутга мэс гаргахгүй, хүч үзэлцэн усанд хаягдсан нь ялагддаг. Үр соёолж шигүү гарвал завсар нь харгана огтолж цацна. Тариан түрүүг мэрэгчид, шувуунаас сэргийлж, овоохой босгож, хонх зүүдэг.

Цагаан буудай -120, арвай 90-95, үстэй арвай 80 хоногт боловсорно. Тарих үр ургамал нь нүцгэн болон халтар арвай, овьёос, шар болон бор будаа, ноён буудай, шахмал цагаан буудай хэмээх 2 сорт, зургаадай хэмээх арвайн сортыг нутагшуулан, арвайн нийт 14 төрөл тариалж байсныг судлаачид тогтоожээ.

Хадаж цайруулах арга: 1 ширхэг үрээс 30-150 ширхэг түрүү гарна. 1 тоорцог үр суулгаж 60кг тариа хурааж байсан. Хадахын өмнө тариа хураах тусгай талбай бэлтгэнэ. Энэ талбайг халх, дөрвөд, баядад үтрэм, захчин торгуудууд цан гэнэ. Түүнийг ус цацаж, шалшуулан хатаадаг. Үтрэмийн голд нь *хүйс мод* зоодог. Тариа хадах үеийн хамтын хөдөлмөрийг Халхчууд *хань дуудах*, Баруун монголчууд *дэмнэх* гэнэ. Идэр дунд насны эмэгтэйчүүд оролцож, хадсан тариаг багцалж тэврүүлж үүрүүлэх ажлыг талбайн эзэн эрхэлнэ. Хаягдсан тариаг түүх ажлыг халхад *малгайчин*, захчин торгуудад *басгачин* гэнэ. Хадалтыг нар, ус халсны дараа эгнээ эгнээгээр хошин дуу, Алтай Хангайн магтаалаар хөл нийлүүлэн хадна. Тариаг гэрийн буйр хэлбэртэй дугуйлж, хана мэт зүрүүлдэн овоолж, түүнийгээ *тэрэм* гэнэ.

Тариаг цайруулахдаа морьдыг холбож, эхний морийг үтрэмийн гол дахи хүйснээс нь уяж тойруулан хөөнө. Морьдыг эхэндээ ширүүн хөөдөг. Ишнээс нь ялгасан тариаг *нэг саванд гаргах* гэж хэлдэг. Түүний дараа дутуу гишгэгдсэн тариаг цөөн мориор гишгүүлэх бөгөөд үүнийг *толгойлох*, *маахайлах*, *мойдох* гэх мэт янз бүрээр нэрлэнэ. Толгойлсоны хойно модон хүрзээр цацаж иш, сүрлийг хийсгэдэг. Үүнийг *нарийн хэндэх*, *улайтгах* гэнэ. Хээнгээс салгасан тариаг элгэ, нэхмэл тулманд хийнэ. Тариаг хэмжих гол нэгж нь *тогоо*.

Монголын ардын тариалан шинэ үеийн механикжсан аж ахуй, үйлдвэрлэл болон хөгжлөө. 1921 онд Хараа гол дахи хятадын тариалангийн газрыг хураан авч, гадаадын харьяатуудад тариалангийн газрыг хугацаатай түрээслүүлэх болов. Мөн тариалангийн сангийн аж ахуй байгуулагдаж, 1930-аад онд 800 га эдэлбэр газар бүхий сангийн аж ахуйтай боллоо. Дайны жилүүдэд

тариаланг гагцхүү үр тарианы чиглэлээр 1941-1945 онд 58%-аар нэмэгдүүлж, ХАА-н нийт бүтээгдэхүүний 10%-ийг үйлдвэрлэх болов. УААА, соёлыг хөгжүүлэх анхдугаар 5 жилийн төлөвлөгөө хэрэгжүүлсний дүнд 1954 он гэхэд 17 САА, 738 тракторын анжис, 297 үр суулгагч, бусад техник нэвтэрч, тариалангийн нийт талбай 42137 га-д хүрэв. Ийнхүү атар эзэмших бэлтгэл хансны учир 1959 оноос *атар эзэмших* их аян өрнөлөө. 1959-1961 онд 260000 га талбайд тариалж, 1 га-аас дунджаар 10 центнер ургаж хурааж, нэг хүнд 268 кг үр тариа оногдох болсноор атрын нэгдүгээр аян зорилтоо хоёр жилд хэрэгжүүлснийг нотлов.

Атрын анхдугаар аянаар 246.7 мянган га атар газар хагалан, 334.6 мянган га-д тариалж 315.0 мянган тонн ургац, 1975 онд хамгийн арвин, 1 га-аас 30-44 центнер ургац хурааж, дотоод хэрэгцээгээ хангаад гадаадад гаргах болжээ.

1976 онд *атрын хоёрдугаар аяныг* амжилттай зохион байгуулж, 12 сангийн аж ахуй шинээр байгуулагдаж, 250.0 мянган га атар газар нэмж хагалсанаар 560-670 гаруй мянган га-д үр тариа тариалж, 680-860 мянган тонн ургац хураан авч дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаж экспортод гаргаж байсан түүхэн уламжлал бий. 1979 оны

байдлаар 48 САА, 11 тэжээлийн аж ахуй, ХАА-н 205 нэгдэлд тариалан эрхэлж, улсаас 72.9 сая төгрөгийн хөрөнгө оруулсан байна. Төмс, хүнсний ногоо, жимс жимсгэний нутагшсан сортыг гарган авч, 1988 он гэхэд төмс тарилт, хураалтын 90 гаруй хувийг механикжуулжээ. Ийнхүү газар тариалангийн хөгжлийн оргил үе 1970-1990 он байлаа. Атар эзэмшин тариалах ажил нь Монголын нийгэм эдийн засгийн амьдралд шинэ амжилт ололтыг авчирсан боловч, 1025.6 мянган га талбайн 561.4 мянган га буюу 46.5% нь эвдрэлд орж, үүнээс 12.9% нь гүнзгий элэгдэлд орсон ноцтой доголдол гарчээ.

1990 оны эдийн засгийн шилжилт болон өмч хувьчлалын үеэр энэ салбар хамгийн их хэлмэгдсэн. Өмч хувьчлалыг алдаатай, тооцоогүй, үр дүнг харахгүй, алсын гаргалгаа муу хийснээс сангийн аж ахуйн удирдлага, эдийн засгийн хувьд уналтад орж, хувьчлал нэрээр хувь хүмүүс машин техникийг бараг дугуйгаар нь салгах нь холгүй авч, усжуулалтын системийг эвдэн, төмөр хоолойнуудыг хятад руу ачуулж сүйтгэсэн. Ингээд 2005 он гэхэд газар тариалангийн салбар бүрэн унасан гэж болно. Энэ үед тариалангийн маш бага талбай ашигласнаар нийт талбайн 80 орчим хувь нь атаршсан. Хуучирсан техникт шинэчлэл хийгээгүйгээс гадна гурил, буудай, төмс, хүнсний ногооныхоо 80 орчим хувийг импортолж байлаа.

Монгол Улсын Засгийн газраас 2008-2010 онд *“Атрын гурав дахь аян тариалангийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”* боловсруулж баталсан. Атрын гурав дахь аяны анхны жил төсвийн хөрөнгө, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас 30 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө гаргаж, техник, үр, бордоо, бусад шинэчлэл хийснээр тодорхой хэмжээгээр газар тариаланд ахиц дэвшил гарлаа. Газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байсан аж ахуйн нэгж, иргэдийн урам сэргэж, энэ салбар хөрөнгө оруулагчдын сонирхол татах болсон. ОХУ-аас 10 сая ам долларын зээл, тусламж авч, техникийн шинэчлэл хийснээр газар тариалангийн техник, хэрэгслийн 70 орчим хувийг шинэчиллээ. Мөн аж ахуйн нэгжүүд үрээ нөөцөлж, улсын нөөцөд нийт 100-аад мянган тн буудай гээд үрийн тодорхой нөөцтэй болсноор 2009 оны байдлаар 385 мянган тн буудай, 150-аад мянган тн төмс, 100 гаруй мянган тн хүнсний ногоо хурааж, дотоодын хэрэгцээний буудайн 90 орчим, төмсний 110 хувь, хүнсний ногоог 70 орчим хувиар хангах хэмжээний амжилттай байна. “Атрын гурав дахь аян тариалангийн

хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр” амжилттай хэрэгжсэнээр газар тариалангийн салбар бие даасан, том хэмжээний салбар болтлоо бэхжин хөгжих үндэс суурь тавигдлаа. Өдгөө Монгол Улсын нийт ажиллах хүчний 40 хувь нь ХАА-н салбарт ажиллаж байгаа бөгөөд газар тариалангийн салбарт ажиллагсдын 72,2 хувь нь жижиг аж ахуй эрхлэгчид байна. Жижиг аж ахуй эрхлэгчид буюу Өрхийн Аж Ахуй эрхлэгч гэдэг нь 5 хүртэл га талбайд төмс, хүнсний ногоо тариалагчид юм. Ийнхүү газар тариалангийн үйлдвэрлэл ардын, хувиа аргацаасан, туслах аж ахуйгаас үндэсний үйлдвэрлэлийн хэмжээнд хүртэл дэвшин хөгжихдөө монгол утга соёлын нэгэн салаа салбар болж чаджээ.

Ногоон аж ахуй ба үйлдвэр

XIX зууны сүүл XX зууны эхэнд Монголд гар ажиллагаатай хувийн болон улсын үйлдвэрийн газрууд нэлээд байсан. Мал аж ахуйн түүхий эд, байгалийн баялгийг боловсруулах хүн амын амьжиргааны хэрэгцээт зүйл үйлдвэрлэх зэрэг ажиллагаатай. Үйлдвэрийн хамгийн нягтаршил ихтэй цэг Нийслэл 1915 оны байдлаар Хятадын үйлчилгээний 464 цэг нийслэлд байрлаж байсан. Орос, Англи, Герман, Америкийн жижиг үйлдвэрийн газрууд Нийслэл, Улиастай, Хангай нуруу, Хөвсгөл нуурын орчим байрлаж, ноос угаах, арьс шир боловсруулах, саван хийх, өлөн гэдэс боловсруулах, архи дарсны ус бэлтгэх, загас агнуур эрхлэх зэрэг боловсруулах гэх мэт нийт 370 гаруй үйлдвэр байсан.

1921 оны хувьсгал ялж, 1923 онд **“Эдийн засгийн үндсэн бодлого”** дэвшүүлэн түүний хүрээнд 1925-1926 онд төмөр, архины завод, цэмбэний фабрик байгуулж, анхны хоршоолсон үйлдвэрүүдийг *Ардын харилцан туслалцах хоршооны харьяанд*

нэгтгэв. Шинэ эргэлтийн бодлогын дүнд Хөвсгөл аймагт барьсан хатгалын ноос угаах үйлдвэр 1930-09-14-д, **“Аж үйлдвэрийн комбинат”**-ын цогцолборыг 1934-03-26-д тус тус ашиглалтад оруулав. Тус комбинат жилд 2790 тонн ноос угаах, 450 тонн эсгий, 85000 м цэмбэ, 70000 хос эсгий гутал, 50000 хос савхин гутал үйлдвэрлэж, 50000 ширхэг шир, 100000 арьс боловсруулж, 23000 нэхий дээл хийх хүчин чадалтай байлаа. Энэ үйлдвэрээс ноос, эсгий, эсгий гутлын, шевроны, торгон савхины зэрэг бие даасан үйлдвэр тусгаарлан хөгжжээ. 1934 онд 2500 квт-ын чадалтай байсан цахилгаан станцын өргөтгөж, 1939 онд 5500 квт-ын хүчтэй болж, **“Төв цахилгаан комбинат”** хэмээх боллоо. Эдгээр нь Монголын аж үйлдвэрийн үндэс байв. Налайх, Өндөрхаан, Сайншанд, Баянтүмэн, Матад, Баянбулаг зэрэг газар чулуун нүүрсний уурхай нээж, 1940 онд 174.2 мянган тонн нүүрс олборложээ. 1940-өөд онд үндэсний нийт бүтээгдэхүүний 24 орчим хувийг аж үйлдвэрийн салбар гаргах болов. 1940, 1945 оныг харьцуулбал, нүүрс олборлолт 45.9%, цахилгаан эрчим хүч 26.6% өсч, хүнсний үйлдвэр 24 байснаа 400, ажилчдын тоо 33.1-ээс 1944 онд 45.5 мянга болж өсөв. БНМАУ-д социализмын үндсийг чухал болох УААА, соёлыг хөгжүүлэх анхдугаар таван жилийн төлөвлөгөөний хүрээнд аж үйлдвэрийн бүтээгдэхүүнийг 96.8%-аар өсгөхөөр зааж, ЗХУ-ын тусламжтайгаар нефть боловсруулах үйлдвэр байгуулж, аж үйлдвэрийн комбинатын зарим завод, төв цахилгаан станц, Налайхын уурхайг засч, өргөтгөн хүнсний үйлдвэрүүдийг шинээр байгуулав. Мах комбинат, мебелийн фабрик, талх, чихэр боов, сүү, савангийн үйлдвэр байгуулагдаж, геологийн эрэл хайгуул, зураглалын ажил өргөжиж, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний жилийн дундаж өсөлт 10 орчим хувьд хүрэв. 1960-аад оноос социализмын материал техникийн баазыг байгуулах зорилт тавьж, нэгд, аж үйлдвэр, хоёрт, аж үйлдвэржсэн ба үйлдвэрийн үндэстэй

газар тариалан, хот орчмын саалийн фермүүдийг хөгжүүлэх ажлыг онцгой эрчимжүүлжээ. Түлш эрчим хүч, уул уурхайн үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд 1970-1990 онд аж үйлдвэрийн жилийн дундаж өсөлт 7.25- 8.75%, үндэсний орлогын жилийн дундаж хурдац 5.1-6.1% байлаа. Энэ бол чамлахааргүй үзүүлэлт мөн. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн 1940 онд улсын үндэсний орлогын 12.7%, 1960 онд 14.6%-ийг эзэлж байсан бол 1990 онд 35%, 1993 онд 39.5%-д хүрч, Монгол улс ХАА-Аж Үйлдвэрийн орон болж чаджээ.

Дүгнэлт

Монголын эдийн засгийн өнөөгийн байдал: Тогтвортой хөгжлийн онол нь эдийн засаг, нийгмийн эерэг хөгжилд хүрэх, хүрээлэн байгаа орчноо ашиглаж доройтуулахгүй байх, залгамж үеийн эрх ашиг, боломжийг хамгаалах зорилтоо хаа сайгүй эвсэг нийцтэй хандага гаргаж хэрэгжүүлэх тулгуур асуудалд төвлөрдөг байна. Дэлхий даяараа ногоон, хүртээмжтэй эдийн засгийг цогцлоохыг зорьж байгаа өнөө үед Монгол Улс ч мөн “Ногоон хөгжлийн бодлого”, “Тогтвортой хөгжлийн зорилт – 2030” зэрэг үндэсний хэмжээний бодлогын баримт бичгүүдийг баталж ногоон эдийн засагт шилжихийг зорьж байгаа билээ. Гэсэн хэдий ч төрөөс гаргасан олон бодлогын баримт бичгүүд нь зөвхөн цаасан дээр үлдэж дорвитой ахиц гарахгүй байна. Тухайлбал дэлхийн ногоон эдийн засгийн индексээр Монгол Улс **80** улс орноос **79-д** эрэмбэлэгдэж байна. Монгол Улс хүрэн эдийн засгаас ногоон эдийн засаг руу хөгжих сонирхолтой байгаа бөгөөд Монголын эдийн засгийн өнөөгийн дүр төрх бол **“Олборлолт чиг баримжаатай ХҮРЭН”** эдийн засагтай орны тоонд зүй ёсоор багтдаг байна. Өөрөөр хэлбэл манай орон **1** ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэхэд **17** кг байгалийн нөөц ашигладаг. Гэтэл дэлхийн дундаж нь **1** ам.долларын бүтээгдэхүүн үйлдвэрлэлд **1.7** кг байгалийн нөөц ашигладаг бол Ази Номхон далайн орнуудын хувьд **3** кг нөөцийг хэрэглэдэг байна. Энэхүү тоо нь Монгол Улсын эдийн засаг хэт үрэлгэн, хоцрогдсон, байгальдаа хаалтай эдийн засагтайг илэрхийлж байгаа юм. Дээрх үндэслэлүүд нь үндэсний хөгжлийн тогтвортой байдлыг шаардаж байна. Бид бүхэн уламжилж ирсэн нүүдэлчдийн ахуйн соёл болсон ногоон эдийн засгийг хөгжүүлж, байгаль

орчныг хамгаалах, уур амьсгал, байгалийн нөөцийг зөв зохистой үр бүтээлтэй ашиглах, ард түмэн эрүүл саруул аж төрөх, урт удаан наслах, бүтээлч амьдрах таатай орчныг өөрөө өөртөө бүрдүүлэж нийгмийн нягтралыг дахин сэргээхэд илтгэлийн зорилго оршиж байгаа юм.

Ашигласан материал, эх үүсвэрийн жагсаалт

1. Г.Жаргалсайхан. Монголын түүхийн үгүүллүүд УБ.,2014
2. Т.Намжим. Монголын аж ахуй эдийн засгийн түүх. УБ.,2001
3. Насанбалжир.Ц. Монголын аж ахуй хөтлөлтийн уламжлал шинэчлэл. УБ.,1978
4. Галиндав.Р. Эрийн гурван наадам. УБ.,1975
5. Гонгор.Д. Халх товчоон. 2. УБ.,1978
6. Гонгоржав.У. Монголын эртний харвуул тэмцээн. УБ.,1982
7. Дамдин.Ж. Буурал анчны тэмдэглэл. УБ.,1966